



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨЛӨВЛӨХ, ХУВААРИЛАХ,
ЗАРЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨМНӨХ АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛҮҮД
ДАВТАГДАН ГАРСААР БАЙНА.**

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг Аудитор Т.Ган-Өлзий Шинжээч Б.Уранбилэг 2017 оны 04 сарын 25 Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70523020 дугаарын утас 70522734 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Дорноговь аймаг Сайншанд сумын 3-р баг Орон нутгийн өмчийн 3 дугаар байр	Товчилсон үгийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй..... 4 Бүлэг 1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах үйл ажиллагааг хууль, журмын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай байна. - Сумдад хуваарилах орлогын шилжүүлгийн хэмжээг батлагдсан аргачлал зааврын дагуу тооцон төлөвлөсөн боловч, төсвийн тодотголыг үндэслэн дахин тооцоолол хийгээгүй байна. - ОНХС-ийн эх үүсвэрийг боломжит нэр төрлөөр төлөвлөөгүй байна. - ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрлөөр бүрдүүлсэн байна. - Сумдад олгох орлогын шилжүүлгийг хуулийн дагуу тооцоогүй, батлагдсан төсвийг бүрэн хуваарилаагүйгээс сумдын ОНХС-д нийт 512.1 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна. Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хууль, журмын зарим заалтыг мөрдөж ажиллаагүй байна. - ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэжээ. - ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-г иргэдээс санал авч эрэмбэлсэн хэдий ч иргэдийн саналаар дэмжигдээгүй 417.6 сая төгрөгийн өртөг бүхий 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлжээ. - Батлагдсан зураг, төсөвгүй ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлсээр байна. - Тендерийн баримт бичгийн иж бүрдэл хангаагүй оролцогчдийг шалгаруулсан байна. - ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. - ТАХ-ны явц болон гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаарлагатай байна. - ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г данс бүртгэлд тусгадаггүй зөрчил гарсаар байна. Бүлэг 3. ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг зохих журмын дагуу зохион байгуулах шаардлагатай байна - ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавих эрх бүхий байгууллагууд үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. - Сумдууд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-т хүргүүлдэг боловч түүнд заавар, журамд заасны дагуу дүн шинжилгээ хийгдээгүй байна. - ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.
---	--

	- ОНХС-ийн заавар холбогдох хууль, тогтоомжтой нийцэж байна. - Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Аудитын дүгнэлт 28 Холбогдох байгууллагын санал 29 Саналд өгөх тайлбар 30 Аудитын зөвлөмж 31
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
НББ	Нягтлан бодох бүртгэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БХНСС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТТХ	Төсвийн тухай хууль
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
ШГ	Шууд гэрээ
ОНО	Олон нийтийн оролцоотой
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, хөтөлбөр болон аймгийн Аудитын газрын 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалтад аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдлээ.

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аймгийн ОНХС, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Эрдэнэ, Замын-Үүд, Сайншанд, Өргөн сумдын ОНХС хамрагдлаа.

Айраг сумын 2016 оны ОНХС-ийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санал эрэмбэлэсэн баримт болон тендер шалгаруулалттай холбоотой баримт материал аймгийн Цагдаагийн газарт шалгагдаж байсан тул аудитад хамрагдаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитын явцад аудит хийгдэж буй байгууллагын зарим албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, холбогдох судалгаа авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Төрийн хяналт шалгалтын стандарт, гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”

Аудит хийж гүйцэтгэсэн бүрэлдэхүүн:

Аудитыг аудитор Т.Ган-Өлзий, шинжээч Б.Уранбилэг нар 2017 оны 03-р сарын 09-ний өдрөөс 04-р сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах
үйл ажиллагааг хууль, журмын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай
байна

1.1 Сумдад хуваарилах орлогын шилжүүлгийн хэмжээг батлагдсан аргачлал зааврын дагуу тооцон төлөвлөсөн боловч, төсвийн тодотголыг үндэслэн дахин тооцоолол хийгээгүй байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9.2-т Аймаг нь ОНХНС-аас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумдад хуваарилахад энэ аргачлалын 3 дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтоохоор заасан байна.

Дээрх журмын дагуу аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Статистикийн хэлтэс, Татварын хэлтсээс гаргасан 2014 оны жилийн эцсийн, 2015 оны эхний хагас жилийн тоо баримтад үндэслэн дараах үзүүлэлтээр тооцоолсон байна. Тухайлбал:

- 1 Сумын хөгжлийн индекс,
- 2 Хүн амын тоо,
- 3 Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ,
- 4 Орон нутгийн татварын идэвх санаачлага зэрэгт харгалзуулжээ.

Орон нутгийн төсөвт 2016 оны 9 дүгээр сард тодотгол хийж, ОНХС-ийн эх үүсвэрийн хэмжээг бууруулан батлахад дээрх аргачлалын дагуу дахин тооцоолоогүйн улмаас сумдын хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгийн харьцаа алдагдсан байна /Хүснэгт №1/.

Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоолол /сая төгрөг/

Хүснэгт №1

Аймаг сумдын нэр	ЗГ-ын 30-р тогтоолоор батлагдсан аргачлалаар		Аймгийн ИТХ-аас баталсан төсөв		Зөрүү /+дутуу, - илүү/
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн
Айраг	217.9	3.9	223.7	4	(5.8)
Алтанширээ	186.5	3.3	194	3.5	(7.5)
Даланжаргалан	222.8	4.0	171.3	3.1	51.5
Дэлгэрэх	182.3	3.3	174.5	3.1	7.8
Иххэт	187.4	3.4	173.9	3.1	13.5
Мандах	224.9	4.0	256.6	4.6	(31.7)
Өргөн	203.8	3.7	173.3	3.1	30.5

Сайхандулаан	201.4	3.6	161	2.9	40.4
Улаанбадрах	217.8	3.9	119.7	2.1	98.1
Хатанбулаг	261.4	4.7	248.2	4.4	13.2
Хөвсгөл	209.0	3.7	198.4	3.6	10.6
Эрдэнэ	241.3	4.3	238.2	4.3	3.1
Сайншанд	433.2	7.8	301.7	5.4	131.5
Замын-Үүд	358.3	6.4	314.7	5.6	43.6
Сумдын дүн	3,347.9	60.0	2949.3	52.9	398.6
Аймаг	2,232.0	40.0	2630.6	47.1	(398.6)
Нийт дүн	5,579.9	100.0	5579.9	100.0	

Аудитаар тодотгол хийгдсэн төсвийг 2016 оны анхны төсөв боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, индекст үндэслэн тооцоход сумдад 398.6 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу хуваарилахаар төлөвлөсөн байна. Тухайлбал, 11 суманд 3.1-131.5 сая төгрөгийн шилжүүлгийг дутуу, 3 суманд 5.8-31.7 сая төгрөгийн шилжүүлгийг илүү олгохоор баталжээ.

1.2 ОНХС-ийн эх үүсвэрийг боломжит нэр төрлөөр төлөвлөөгүй байна.

ТТХ-ийн 60.2, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6 дугаар зүйлийн 6.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар тооцож төлөвлөнө” гэж заажээ:

- 6.1.1-д “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг”,
- 6.1.2-т “аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг”,
- 6.1.3-т “татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр”,
- 6.1.4-т “зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр”,
- 6.1.5-д “тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж”

Төсвийн жилд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бусад орлогын эх үүсвэрийг тооцож төлөвлөөгүй байна. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг сүүлийн 3 жилээр харуулав.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр /сая төгрөгөөр/

Хүснэгт №2

№	Орлогын төрөл	2014 он		2015 он		2016 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	ОНХНС	10146.8	7435.3	4755.7	3935.7	5579.9	5579.9
2	Үндсэн тэнцлийн ашгаас		266.3	373.8	167.8		
3	ОНХС-ийн дансны үлдэгдлээс		291.1				135.8
4	Хандив тусламжийн орлого						34.8
Нийт дүн		10146.8	7992.7	5129.5	4103.5	5579.9	5750.5

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 3.4-т “Аймаг, нийслэл сум, дүүрэг нь Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрүүдээр нэмэлт орлого олж ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой бол уг эх үүсвэрийн дүнгээр ОНХС-ийн эх үүсвэрээ нэмэгдүүлэн батлуулж болно” гэж заасан байна.

Тайлант онд ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр олгодог хандив, тусламжийн орлогыг тооцоогүй байна. Тухайлбал:

Газрын тосны газар болон Доньшен газрын тос ХХК-ийн хооронд 2011 онд байгуулсан гэрээний заасны дагуу орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр 30.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг байна. Уг орлогыг 2016 оны төсөвт тусгаагүй байна.

Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 8.7-д “ОНХС-ийн тухайн жилд зарцуулагдаагүй үлдэгдэл болон худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт нь ОНХС-ийн дансанд үлдэж, дараа жилийн сангийн эх үүсвэрт тусгагдан ИТХ-аар батлагдан хэрэгжих боломжтой” гэж заасан байна.

Гэтэл аймгийн ОНХС-ийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл 135.8 сая төгрөгийг тайлант оны ОНХС-ийн орлогын эх үүсвэрт тусгаагүй, ИТХ-аар батлуулаагүй байна.

Цаашид аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр тогтмол төвлөрдөг хандив, тусламжийн орлого болон ОНХС-ийн өмнөх жилийн үлдэгдийг ОНХС-ийн орлогын эх үүсвэрт тусган аймгийн ИТХ-аар батлуулан зарцуулах шаардлагатай байна.

1.3 ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрлөөр бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох шилжүүлэг болон орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон эх үүсвэр, зардлыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламжийн орлого зэргээс бүрдүүлэхээр заажээ.

Аймгийн ОНХС-д 2016 онд өмнөх оны эцсийн үлдэгдэл 31.6 сая төгрөг, ОНХНС-аас орлогын шилжүүлэг 5,579.9 сая төгрөг, хандив тусламжийн орлого 34.8 сая төгрөг, нийт 5,646.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэж, гүйцэтгэлээр 5,496.6 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцсийн байдлаар 149.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хандив тусламжаас нийт 34.8 сая төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд 30.0 сая төгрөгийг “Доньшен газрын тос” ХХК, 4.8 сая төгрөгийг Зон Хэн Юу Тиан” ХХК-иас тус тус орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор шилжүүлсэн байна.

Сумдын ОНХС-ийн оны эхний үлдэгдэл 104.2 сая төгрөг, аймгийн ОНХС-аас 2,835.8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг авч гүйцэтгэлээр 2,895.6 сая төгрөгийг зарцуулж, 44.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Цаашид ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг үндслэлтэй тооцож, тухайн жилийн хуваарилагдсан хөрөнгийг бүрэн ашиглах шаардлагатай байна.

1.4 Сумдад олгох орлогын шилжүүлгийг хуулийн дагуу тооцоогүй, батлагдсан төсвийг бүрэн хуваарилаагүйгээс сумдын ОНХС-д нийт 512.1 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн сангаас энэ хуулийн 59.1.1-59.1.5-д заасан орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэж заасан.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/06 дугаар тогтоолоор 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г 6,366.7 сая төгрөгөөр баталж, үүнээс 60 хувь буюу 3,820.0 сая төгрөгийн ТАХ-г сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар ОНХС-аас тус аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 12.4 хувь буюу 786.8 сая төгрөгөөр бууруулж, аймгийн ОНХС-д 5,579.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор баталсан байна.

Уг тодотголтой холбогдуулан аймгийн ИТХ 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаар ОНХС-ийн 2016 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 5,579.9 сая төгрөг болгон тодотгон баталсан байна. Тодотголоор өмнөх он болон тайлант онд гүйцэтгэл нь бүрэн гарсан ажлуудын санхүүжилтийг олгож дуусгахаар шийдвэрлэсэн тул сумдад 52.9 хувь буюу 2,949.3 сая төгрөгийг, аймгийн ОНХС-д 47.1 хувь буюу 2,630.6 сая төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн байна. /Хүснэгт №3/

Орон нутгийн хөгжлийн санд хуваарилахаар батлагдсан төсөв /сая төгрөг/

Хүснэгт №3

Орлогын шилжүүлэг	Аймгийн ИТХ-аас баталсан				Аудитаарх тооцоолол		Зөрүү /4-6/
	Анх баталсан төсөв	Хувь	Тодотгосон төсөв	Хувь	ЗГ-ийн 30-р тогтоол	Хувь	
1	2	3	4	5	6	7	8
Сумдын ОНХС	3,820.0	60	2,949.3	52.9	3,347.9	60	-398.6
Аймгийн ОНХС	2,546.7	40	2,630.6	47.1	2,232.0	40	398.6
Нийт дүн	6,366.7	100	5,579.9	100	5,579.9	100	0.0

Дээрх тооцооллоос харахад 2016 оны 9 дүгээр сард хийгдсэн төсвийн тодотголоор сумдын ОНХС-д 3,347.9 саяаас доошгүй төгрөгийг хуваарилах байтал 2,949.3 сая төгрөгийг олгохоор баталсан нь нийт сумдад хуваариалах шилжүүлгийн дүнгээс 398.6 сая төгрөгийг дутуу тооцож төлөвлөсөн байна.

Мөн батлагдсан төсвийг олгосон санхүүжилттэй харьцуулж үзэхэд сумдад 2,949.3 сая төгрөг хуваарилахаар баталсан ч 2,835.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байгаа нь ИТХ-аар батлуулсан төлөвлөгөөнөөс 113.5 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.

ОНХС-ийн орлогын шилжүүлгийн хуваарилалт, сумдаар /сая төгрөг/

Хүснэгт №4

Аймаг сумдын нэр	Аймгийн ИТХ-аас баталсан төсөв		Олгосон санхүүжилт буюу гүйцэтгэл		Зөрүү
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн
Айраг	223.7	4	210.7	3.8	13.0
Алтанширээ	194	3.5	192	3.4	2.0
Даланжаргалан	171.3	3.1	169.8	3	1.5
Дэлгэрэх	174.5	3.1	174.9	3.1	-0.4
Иххэт	173.9	3.1	173.8	3.1	0.1
Мандах	256.6	4.6	243.7	4.4	12.9
Өргөн	173.3	3.1	172.8	3.1	0.5
Сайхандулаан	161	2.9	161	2.9	0.0
Улаанбадрах	119.7	2.1	114.8	2.1	4.9
Хатанбулаг	248.2	4.4	244.9	4.4	3.3
Хөвсгөл	198.4	3.6	173.1	3.1	25.3
Эрдэнэ	238.2	4.3	232.8	4.2	5.4
Сайншанд	301.7	5.4	256.7	4.6	45.0
Замын-Үүд	314.7	5.6	314.7	5.6	0.0
Сумдын дүн	2949.3	52.9	2835.8	50.8	113.5
Аймаг	2630.6	47.1	2744.1	49.2	-113.5
Нийт дүн	5579.9	100	5579.9	100	

Төсвийн тухай хуулийн 59.2-ийг зөрчсөнөөр сумдад төлөвлөсөн төсөл, арга хэмжээ батлагдсан зураг төсвийн дагуу хийгдэхгүй байх, зарим төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх зэрэг сөрөг талууд гарсан байна.

Цаашид ОНХС-ийн эх үүсвэр батлагдсан төлөвлөгөөнөөс буурсан тохиолдолд аймаг болон сум бүрт олгох шилжүүлгийн хэмжээг төсвийн өөрчлөлттэй уялдуулан дахин тооцоолох, Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хууль, журмын зарим заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

2.1 ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд нийт 5,562.0 сая төгрөгийн 124 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2016 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ /сая төгрөг/

Хүснэгт №5

Орон нутгийн хөгжлийн сан	Өмнөх оноос шилжиж ирсэн		2016 онд шинээр хэрэгжүүлэх		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумдын ОНХС	16	470.1	93	2,461.3	109	2931.4
Аймгийн ОНХС	8	1,773.5	7	857.1	15	2630.6
Нийт	24	2243.6	100	3318.4	124	5562.0

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4 дүгээр бүлгийн 4.1-д “ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх” гэж заасан байна.

2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Засаг даргын шийдвэрээр ажлын хэсэг байгуулан урьдчилсан жагсаалтыг боловсруулж, аймгийн чиг үүрэгт хамаарах нийт 28 төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг бэлтгэжээ.



ОНХС-аар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ын ангилал

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, тухайн шатны ИТХ-аар батлуулсан байна. /График 1/

ОНХС-ийн зааврын 3.5-д “Засаг даргын тамгын газар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл, иргэдийн хурлаас гарсан санал, тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана” гэж заасан байтал сумдын 2016 төсвийн танилцуулгад энэ талаар дэлгэрэнгүй тусгаагүй байв.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-г иргэдээс санал авч эрэмбэлсэн хэдий ч иргэдийн саналаар дэмжигдээгүй 225.2 сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 63.1-д “Баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна”, мөн орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.2-т “Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлсэн байх” гэж заасан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжих ТАХ-нд 14 сумын 3030 иргэнээс 364 санал авч, урьдчилсан жагсаалтад тусгагдсан нийт 28 төсөл, арга хэмжээг иргэдэд таницуулж, санал авах ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн зааварт тусгагдсан цаглабарын дагуу бүх сумдад зохион байгуулсан. Үүнээс гадна иргэдээс нэмэлт 22 төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгуулах санал гарч нэгтгэсэн байна.

Сумдын багийн Засаг дарга иргэдээс ирүүлсэн саналыг БИНХ-д хэлэлцүүлэхдээ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын 12.2.2 а, б, в, г-д заасны дагуу хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг үзүүлэлтүүдийг тооцоолж тусгахаар заасан байтал хийсэн тооцоолол байхгүй байна.

Энэ нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд төсөвт өртөг, үр ашиг, үр өгөөж нь тодорхойгүй төсөл арга хэмжээ тусгаж, батлах нөхцлийг бий болгож байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 5.2-т “БИНХ-ын дарга ирэх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтын хэлэлцэх, санал хураах хурлыг жил бүрийн 5 дугаар сард багтаан зохион байгуулна” гэж заасан байтал Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдууд 6-10 дугаар саруудад зохион байгуулжээ.

Сумдын БИНХ нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө тухайн нутаг дэвсгэрт оршин суугч иргэдээс санал авсан хэдий ч иргэдийн

саналаар эрэмбэлэгдээгүй 225.2 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Улаанбадрах сум

- ЕБС-ийн дотуур байрны бохирын системийн засварын ажил 6.5 сая.

Хөвсгөл сум

- Төв садны тохижилтын ажил 50.0 сая
- ЕБС-ийн биеийн тамирын талбайн засварын ажил 9.9 сая
- Худгийн тоног төхөөрөмж авах 6.6 сая
- Ус цэвэршүүлэх үйлдвэрийн халаалтын систем 2.9 сая
- Эмнэлэгийн амрах байр 1.5 сая

Хатанбулаг сум

- Хог зөөврийн машин авах 34.8 сая
- Хогийн сав хийх ажил 19.5 сая
- Эргэл багийн тэжээлийн агуулахын барилга 20.0 сая

Мандах сум

- Эм эргэлтийн сангийн барилгын ажил 42.6
- Соёлын төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авах 30.9 сая

Энэ нь Төвсийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3, 63.4-т БИНХ-аас ирүүлсэн саналыг сумын ЗДТГ эрэмбэлж батлуулах гэж заасантай нийцэхгүй байна.

Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сумдын Засаг дарга нарт дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

АУДИТЫН ЯВЦАД ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Аудитын явцад 14 сумын 498 иргэнээс ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээлэл, иргэдийн идэвх оролцоог судлах зорилгоор санал асуулга авахад судалгаанд хамрагдсан иргэдийн 25 хувь нь сайн мэднэ, 41 хувь нь сонссон, гэхдээ сайн мэдэхгүй, 34 хувь нь огт мэдээлэл байхгүй гэж хариулсан байна.

Багаас зохион байгуулсан ОНСХ-ийн талаарх асуудал хэлэлцэх хуралд оролцож байсан уу гэсэн асуулгад судалгаанд хамрагдсан иргэдийн 17 хувь нь буюу 83 иргэн байнга, 38 хувь нь буюу 185 иргэн хааяа, 45 хувь нь буюу 222 иргэн огт үгүй гэж хариулсан байна.

Хэрэв БИНХ-д оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаарх асуулгад 348 иргэн санал өгч, цаанаасаа бэлтгэсэн жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг гэж 18 хувь буюу 63 иргэн хариулсан бол, 34 хувь нь буюу 119 иргэн

оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн ТАХ-ыг хэлэлцүүлдэг гэсэн хариултыг сонгосон нь хамгийн их санал авсан байна.

2.3 Батлагдсан зураг, төсөвгүй ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлсээр байна.

ОНХС-ийн зааврын 4.7-д “Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэж заасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон барилга байгууламж, засварын ажлыг мэргэжлийн байгууллагаар баталгаажсан зураг төсөвт үндэслэн батлаж, гүйцэтгэсэн байна. Харин тоног төхөөрөмж нийлүүлэх болон бусад төсөл, арга хэмжээний төсвийг захиалагч байгууллага өөрсдөө боловсруулсан байна.

2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих дараах төсөл, арга хэмжээг ажлын зураг төсөвгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдээгүй, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг боловсруулаагүй байхад ИТХ-аар баталсан байна. Үүнд:

Замын-Үүд сум

- ЦДАШ, гэрэлтүүлгийн ажил 89.8 сая
- Сүлд багийн 10-р хэсгийн тохижилтын ажил 151.8 сая
- Сүлд багийн 11-р хэсгийн тохижилтын ажил 94.5 сая
- Хүндэтгэлийн хаалганы тохижилтын ажил 35.0 сая

Хатанбулаг сум

- Эргэл багийн иргэдэд үйлчлэх төвийн барилгын ажил 20.0 сая
- Эргэл багийн тэжээлийн агуулах барих барилгын ажил 20.0 сая

Хөвсгөл сум


- Соёлын төв, биеийн талбайн засвар 16.9 сая
- Гудамжны гэрэлтүүлэг, Цэцэрлэгийн гадна тоглоом 31.9 сая
- ЦДАШ-ын өргөтгөл, багийн төвийн цахилгаанжуулалт 42.5 сая
- Худгийн тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх үйлдвэрийн халаалт 9.5 сая
- Төв саадны тохижилт, хүндэтгэлийн өргөөний тохижилт, Эмнэлэгийн амрах байр 61.5 сая
- Хогийн цэг шуух цэгцлэх ажил 23.0 сая

Дээрх төсөл, арга хэмжээг ажлын хэсэг хүлээн авахдаа техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн гэж комиссын актыг үйлдсэн байна.

Хөвсгөл, Хатанбулаг, Замын-Үүд сумдын Засаг дарга нарт дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.4. Тендерийн баримт бичгийн иж бүрдэл хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

Төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр 3,318.4 сая төгрөгийн 100 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 11, харьцуулалтын аргаар 48, шууд гэрээгээр 30, олон нийтийн оролцоотой 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.



ТАХ-ны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХАА-ны арга

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг аймагт ОНӨГ, сумдад ЗДТГ-т зохион байгуулжээ.

Зарим сумдад тендерийн баримт бичгийн иж бүрдэл хангаагүй тендерт оролцогчийг шалгаруулсан байна. Үүнд:

- Хөвсгөл сумын 23.0 сая төгрөгийн өртөг бүхий хогийн цэгийг шуух, цэгцлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь ижил төрлийн ажил, үйлчилгээ үзүүлсэн туршлагыг нотлох баримт, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, чадварын мэдээлэл, үйл ажиллагааны хуваарь, татварын тодорхойлолт, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгаа, тусгай зөвшөөрөл болон төсөв тооцоо зэрэг шаардлагатай бичиг баримтыг ирүүлээгүй “Хүрэл унага” ХХК-ийг шалгаруулсан.
- Сайншанд сумын Зүүнбаян багт хийгдэх 30.0 сая төгрөгийн өртөг бүхий 78 айлын сантехник угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Цэцэйхэн марал” ХХК-ийг шалгаруулсан байна. Тендерийн баримт бичигт тус байгууллагын мэргэжлийн боловсон хүчин, техник, тоног төхөөрөмжийн чадвар, ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн тухай мэдээлэл хангалтгүй, баримтын бүрдэл дутуу байв.
- Хөвсгөл сумын 24.5 сая төгрөгийн өртөг бүхий гудамжны гэрэлтүүлгийн ажлын тендерт шалгарсан “Чингүүд” ХХК нь үнийн санал, ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, актаас өөр шаардлагатай баримтыг ирүүлээгүй байна. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл байхгүй байна.

2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 58.4 болон ОНХС-ийн зааврын 7.2, 7.4-т тус сангийн хөрөнгөөр аймаг, сумдын хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тусгаж өгсөн байна.

Аймгийн ОНХС-аас дээрх хууль, тогтоомжид заасан чиг үүрэгт тусгагдсан ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Харин сумдын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй дараах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:



Мандах суманд 42.6 сая төгрөгийн өртөг бүхий Эм эргэлтийн сангийн барилгыг шинээр бариулсан.



Эрдэнэ суманд 25.0 сая төгрөгийн өртөг бүхий цаг уурын станцын барилгыг шинээр бариулсан.

- Хатанбулаг сумын Эргэл багт 20.0 сая төгрөгөөр өвс тэжээлийн агуулах барих ажлыг өөрчлөн Эргэл багийн иргэдэд үйлчлэх төвийн дэргэд гал тогооны барилга барьсан.



Эргэл багийн гал тогооны барилга

- Мандах суманд 17.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий мал нядалгааны цэг байгуулсан байна.



Мандах сумын мал нядалгааны цэг

- Иххэтсумын Эм эргэлтийн сангийн байрыг 5.0 сая төгрөгөөр засварласан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ” сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

Мандах, Эрдэнэ, Иххэт, Хатанбулаг сумдын Засаг дарга нарт дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ОНХС-ийн хөрөнгөөс бараа, материал худалдан авч, урамшуулал олгосон байна. Үүнд:

- Сайншанд сумын ОНХС-аас 63.0 мянган төгрөгөөр флаш, диктафон худалдаж авахад, 48.7 мянган төгрөгийг ЕБС-ийн үдийн цайны үнэлгээний хороонд ажилласан гишүүдийн урамшуулалд тус тус зарцуулсан байна.
- Сайхандулаан суманд “Мэдээллийн тоног төхөөрөмж” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 1500.0 мянган төгрөгийн өртөг бүхий архивын шүүгээ 2 ширхэгийг авсан байна.
- Хөвсгөл сумын ОНХС-аас 759.9 мянган төгрөгийг сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь ОНХС-ийн зааврын 4.4-т “... сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Зориулалт бусаар зарцуулсан дээрх хөрөнгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.6 ТАХ-ний явц болон гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2016 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт шинээр эхлэх 3,584.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 100 ТАХ-ний гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 3,531.2 сая төгрөгийн 98 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 53.6 сая төгрөгийн 2 ТАХ дутуу хэрэгжсэн байна. Тухайн онд бүрэн хэрэгжсэн ажлуудаас 14 ажлын 240.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ.

Тайлант онд 207.1 сая төгрөгийн барилга угсралт, 321.8 сая төгрөгийн гэрэлтүүлэг шинээр хийх, 261.2 сая төгрөгийн барилгын засвар, 637.1 сая төгрөгийн цэвэр бохир, дулааны шугам шинэчлэх, өргөтгөх ажил хэрэгжсэн байна.

Гэтэл дээрх ТАХ-ний 14 хувь буюу 4 барилга угсралтын ажилд аймгийн ГХБХБГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ГХБХБГ нь ихэвчлэн аймгийн төвд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд сумдад хэрэгжсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг тухайн сумын ЗДТГ-аас гүйцэтгэж, зарим ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчин дутмаг, тухайн ажлын төсөвт захиалагчийн

хяналтын зардлыг тусгаагүй, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгээгүй зэргээс ашиглалтын шаардлага хангахгүй чанаргүй ажил хийгдсээр байна. Тухайлбал:

- Улаанбадрах сумын 20.0 сая төгрөгийн өртөг бүхий хуучин халуун усны барилгын засварын ажлыг гүйцэтгэхдээ цонхны давцанг чулуугаар хийхээр төсөвлөсөн байхад хуванцар материалаар хийсэн, шалны гадаргууг халтирдаггүй барзгар плита наах байсныг гөлгөр нимгэн плитагаар орлуулсан байв. Мөн барилгын гадна талд усны хаялга хийхээр техникийн тодорхойлолтод заасан боловч уг ажлыг хийгээгүй байна. Уг барилгыг нийтийн ахуй үйлчилгээний зориулалтаар засварласан боловч одоог хүртэл ашиглаагүй байна.

- Улаанбадрах сумын ЕБС-ийн сурагчдын дотуур байрны цэвэр бохирын усны шугам шинэчилэх ажлыг 6.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Уг ажлыг ажлын хэсэг хүлээн авснаас хойш 1 сарын дараа шугам хагарч ашиглагдахгүй болсон байна. Тухайн ажлыг гүйцэтгэх үед захиалагчийн хяналт хангалтгүй тавьсан, гүйцэтгэгч



нь ил, далд ажлын акт үйлдээгүй зэрэг зөрчилтэй байна.

Улаанбадрах сумын ЕБС-ийн дотуур байр



Айраг сумын ахмадын өргөө

Айраг сумын 6.5 сая төгрөгийн өртөг бүхий ахмадын өргөөний засварын ажлыг иргэн А.Энхбаатартай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ. Тус ажлын гүйцэтгэлээр хуучин паркетан шалыг модон шалаар сольсон бөгөөд ашиглалтад ороод удаагүй байхад шаланд зай үүсч, будаг ховхорч дахин завсарлах шаардлагатай болсон байна.

- Айраг сумын 52.6 сая төгрөгийн өртөг бүхий ЕБС-ийн дотуур байрны сантехник, цахилгааны засварын ажлын гүйцэтгэгчээр “Төмөрт Өргөө” ХХК ажилласан байна. Засварын ажлыг хүлээж аваад удаагүй байхад гал тогооны өрөөний цахилгааны утас нь тоног төхөөрөмж залгахаар халдаг, дотор болон гадаа хананд суулгасан гэрэл асахгүй болсон, хүүхдийн усанд орох зориулалттай душд агааржуулалт хийгдээгүйгээс чийг болон бохир үнэртэх зэрэг хүндрэл гарсан байна.

- Иххэт сумын соёлын төв, ЕБС-ийн дотуур байрны дээвэр засварын 69.1 сая төгрөгийн өртөг бүхий ажил, мөн хүүхдийн цэцэрлэгийн барилгын дээвэр засварын 36.7 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг БДЗ ХХК гүйцэтгэсэн байна. ЕБС-ийн дотуур байрны дээвэр засварын ажил чанаргүй хийгдэж хүлээж аваад 1 жил болоогүй байхад дээврээс ус гоожиж эхэлсэн, цэцэрлэгийн барилгын дээврээс ус гоожсоны улмаас дотор хана, таазны зарим хэсгийг засварлах, дээврийг дахин засуулах шаардлагатай болсон байна.

Дээрх чанаргүй, дутуу хийгдсэн ажлуудыг дахин гүйцэтгүүлэхээр албан шаардлага хүргүүлээ.

ГҮЙЦЭТГЭЛ ГАРААГҮЙ БАЙХАД САНХҮҮЖҮҮЛСЭН АЖЛУУД.

Зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон зөрчил гарсан байна. Үүнд:

- Сайншанд сумын Зүүнбаян багийн 78 айлын орон сууцны 30.0 сая төгрөгийн өртөг бүхий сантехник угсралтын ажлын гүйцэтгэл гараагүй байхад нийт санхүүжилтийн 68 хувийг олгосон байна. Тендерийн баримт бичгийн 18.2-г зөрчин захиалагчийн зөвшөөрөлгүйгээр ажлыг 28 хоногоос дээш хугацаанд зогсоосон байхад Сайншанд сумын ЗДТГ-аас уг ажилд хяналт тавиагүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Сайншанд сумын Зүүнбаян багийн хүүхдийн цэцэрлэгийн 24.8 сая төгрөгийн өртөг бүхий гадна тоглоомын талбай тохижуулах ажилд шалгарсан “Говь тарвас” ХХК ажлыг дутуу гүйцэтгэсэн, элсний талбай хийгээгүй, байхад ажлыг хүлээж авсан байна. Мөн зарим тоглоом болон гэрэлтүүлэг эвдэрсэн байв. Гүйцэтгэгчид гэрээний үнийн дүнгийн 70 хувийг олгожээ. Уг ажлыг бүрэн хийж гүйцэтгүүлэх, эвдэрсэн, шаардлага хангахгүй байгаа тоглоомыг засах, солих, дутуу ажлыг дуусгуулах тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.
- Сайншанд сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 13/03 дугаар тогтоолоор 4.9 сая төгрөгөөр хогийн сав нийлүүлэх ажлыг батлан, 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01/07 дугаар тогтоолоор уг ТАХ-г хассан байна. Гэтэл уг ТАХ-г хэрэгжүүлэхээр 2016 оны 2 дугаар сард шууд гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл гараагүй, хүлээж авсан комиссын акт байхгүй байхад ОНХС-аас 1.0 сая төгрөг, БХНСС-ийн данснаас 2.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид шилжүүлсэн байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжиж эхэлсэн Сайншанд сумын Зүүнбаян багийн “Спорт цогцолбор барих ажил”-ыг “СНТ групп” ХХК 758.0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна. Тус ажилд 2015 онд 96.0 сая төгрөг, 2016 онд 695.9 сая төгрөг, нийт 791.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, гэрээний үнийн дүнгээс 33.9 сая төгрөгийг илүү шилжүүлжээ. Иймд “СНТ групп” ХХК-д



илүү олгосон 33.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн актыг тогтоохоор шийдвэрлэв.

ЧАНАРГҮЙ ХИЙГДСЭН АЖЛУУД.

- Өргөн суманд 44.7 сая төгрөгийн өртөг бүхий шилмэл омгийн хээлтүүлэгч авах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд ажлын тоо хэмжээнд нас бие гүйцсэн буур 2, бух 2, хуц 20, ухна 20 нийт 44 ширхэг мал авахаар заасан байна. Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Номастиранч” ХХК шалгарсан ба малыг хүлээлгэн өгөхдөө гэрээнд заасан тоо ширхэгээр өгсөн ч 32 ширхэг мал нь хээлтүүлэх насанд хүрээгүй байна. Үүнд: 3 бяруун бух, 8 хурган хуц, 21 ишгэн ухна байна. Гүйцэтгэгч нь нас бие гүйцээгүй мал өгсөн шалтгаанаар 9 ухна нэмж өгсөн байна. Захиалагч тал гэрээнд заасан малыг нас биенд хүргэж авахаар нэмэлт гэрээ байгуулсан байна.
- Хөвсгөл сумын хогийн цэг цэгцлэх, шуух 23.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг “Хүрэл унага” ХХК хийж гүйцэтгэхээр шалгарсан байна. Уг ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгээгүй, ажлын гүйцэтгэл дутуу гэсэн шалтгаанаар хүлээж аваагүй байна.



Хөвсгөл сумын хогийн цэгийг цэгцлэх, шуух ажлын гүйцэтгэл

- Даланжаргалан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 146.8 сая төгрөгийн төсөвтэй “Сумын төв зам дагуух тохижилтын ажил”-ыг “Дөрвөн зэт” ХХК 146.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан тухайн онд 20.0 сая төгрөг, 2016 он 75.0 сая төгрөг нийт 95.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Гэрээнд ажлыг 2015.09.15-ны өдөр эхэлж, 2015.10.15-ны өдөр ашиглалтад оруулахаар тусгасан ч замын бордюр, гэрэлтүүлгийн ажлыг маш хангалтгүй гүйцэтгэж, явган хүний зам тавих ажлыг одоог хүртэл хийгдээгүй байна.

Хөвсгөл болон Даланжаргалан сумдад дутуу хийгдсэн дээрх ажлыг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгүүлж, ажлыг дуусгуулах албан шаардлага бичихээр шийдвэрлэв.

2.7. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г данс бүртгэлд тусгадаггүй зөрчил гарсаар байна.

НББ-ийн тухай хуулийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг НББ-д заавал бүртгэнэ, ОНХС-ийн зааврын 8.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэж заасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн 810.9 сая төгрөгийн ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- Замын-Үүд сум нийт 371.1 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй. Тус сумын Засаг дарга Замын-Үүд НААҮ ОНӨХХК-д дээрх хөрөнгийг данс бүртгэлд тусгахаар захирамж гаргасан боловч нийт үнийн дүнгээр буюу хөрөнгө тус бүрийг үнэлээгүйгээс Замын-Үүд НААҮ ОНӨХХК нь бүртгэлд тусгаагүй байна.
- Замын-Үүд сумын 192.6 сая төгрөгийн өртөг бүхий авто замыг сайжруулах ажлыг “Борхойн зам” ХХК гүйцэтгэсэн байна. Уг ажлыг аймгийн Засаг даргын 2016 оны А/150 дугаар захирамжаар данс бүртгэлд тусгахаар Замын-Үүд сумын Засаг даргад үүрэг болгосон ч холбогдох байгууллагын санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Сайншанд сумын 2 дугаар багийн ЦДАШ, дэд станц барих ажлыг “Билгүүн Од констракшн” ХХК 247.2 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Тус ажлыг аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/179 дугаар захирамжаар НББ-д тусгахыг Сайншанд сумын Засаг даргад үүрэг болгосон ч холбогдох байгууллагын санхүүгийн тайланд тусгаагүй байна.

ТАХ-г НББ-д хөрөнгө тус бүрээр үнэлж бүртгэхгүйгээр тухайн ажлын гэрээний үнийн дүнгээр тусгах тохиолдол гарч байна. Тухайлбал:

- Сайншанд сумын V багийн 24.8 сая төгрөгийн өртөг бүхий тоглоомын талбайг данс бүртгэлд хөрөнгийн нэр төрөл тус бүрээр үнэлж тооцолгүй нийт дүнгээр нэг хөрөнгө гэж бүртгэсэн байна.
- Алтанширээ сумын 36.3 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэн тохижуулах, 19.6 сая төгрөгийн өртөг бүхий гудамжны гэрэлтүүлэг, 5.5 сая төгрөгийн өртөг бүхий хүүхдийн тоглоомын талбайд тоглоом нэмэх, 21.4 сая төгрөгийн өртөг бүхий камержуулах зэрэг ажлуудыг данс бүртгэлд хөрөнгө тус бүрээр тусгаагүй байна.
- Сайхандулаан суманд нийт 68.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худгийн 5 цооног гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнийг орон нутгийн өмчид бүртгэхдээ цооног бүрээр үнэлээгүй, 2 худаг гэж бүртгэлд тусгасан байна.

Данс бүртгэлд огт тусгаагүй болон нийт гэрээний үнийн дүнгээр тусгасан ТАХ-г НББ-д нэмж тусгуулах, залруулж бүртгэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

БҮЛЭГ 3

ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг зохих журмын дагуу зохион байгуулах шаардлагатай байна

3.1 ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавих эрх бүхий байгууллагууд үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр бүлгийн 9.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана” гэж заасан байна.

Дээрх заалтыг хангаж ажилласан эсэхийг шалгахад дараах байдалтай байв.

Аймгийн ИТХ-аас 2016 онд тус сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад нэгдсэн журмаар хяналт шалгалт хийгээгүй боловч Замын-Үүд суманд АИТХ-аас батлагдсан удирдамжийн дагуу тус сумын ОНХС-ийн хэрэгжилтэд шалгалт явуулж, үр дүнд хяналт шинжилгээ хийж, сумын Засаг даргад чиглэл өгч ажиллажээ.

Сумдын ИТХ-аас тухайн шатны ОНХС-ийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байдлыг шалгахад зөвхөн Хатанбулаг, Айраг, Иххэт сумд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байв. Үүнд:

- Хатанбулаг сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь 2016 онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хийж гүйцэтгэсэн ТАХ-г иргэдийн оролцоо, төлөвлөлт, ХАА, гэрээний хэрэгжилт, ажлын үр дүн зэрэг үзүүлэлтээр дүгнэж, ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.
- Иххэт сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь тус сангийн хөрөнгийн зарцуулалтад 2016 онд 4 удаагийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба хийж гүйцэтгэсэн ажлын талаар сумын ИТХ-аар хэлэлцэн, холбогдох санал дүгнэлтийг гаргаж ажилласан байна.
- Айраг сумын ИТХ-аас томилсон ажлын хэсэг хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээнд 2016 оны 3 дугаар сард хяналт хийж, ажлын явцтай танилцан, гүйцэтгэгчид ажил сайжруулах чиглэл өгч ажилласан байна. Мөн хийсэн ажлын тайлан, дүгнэлт, саналыг сумын Засаг даргад хүргүүлж ажиллажээ.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т ТЕЗ нь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “... арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, ОНХС-ийн зааврын 9 дүгээр бүлгийн 9.2-т “ОНХС-аас оруулж байгаа

хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016 онд Айраг сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Тус шалгалтад Айраг сумын ОНХС-ийн 2013-2015 он болон 2016 оны эхний 9 сарын ажлыг хамруулж, холбогдох дүгнэлтийг гарган, 6.5 сая төгрөгийн 4 акт тогтоож, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан ажиллажээ.

3.2 Сумдууд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-т хүргүүлдэг боловч түүнд заавар, журамд заасны дагуу дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 10.1-д ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайланг сумдууд жил бүрийн 7 дугаар сарын 10-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлэх, мөн ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна гэж заасан байдаг.

Дээрх журмын дагуу 14 сумаас ОНХС-ийн хэрэгжилтийн 2016 оны хагас, бүтэн жилийн мэдээ, тайланг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлсэн боловч аймгийн Засаг дарга ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилоогүй байна.

Мөн зааврын 10.2-т “Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум бүрээр гарган аймгийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 02 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ”, 10.3-т уг хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлнэ гэж заасан байна.

Дээрх ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсгийг томилоогүйгээс ОНХС-ийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулах, мэдээ, тайланг гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ талаар аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтнээс тодруулахад “ОНХС-ийн гүйцэтгэлийн мэдээг сумдаас тогтоосон хугацаанд авсан боловч хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгдэж байгаагүй. Мөн сумдад шалгалтаар ажиллах боломжгүй байдаг” гэж тайлбарлав.

3.3 ОНХС-ийн хөрөнгийн хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 68.3-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ”, мөн ОНХС-ийн зааврын 11.2.3-т төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулж, нийтэд мэдээлэхээр заасан байна.

Аудитын явцад нийт 14 сум болон аймгийн ЗДТГ-т мэдээллийн самбараар олон нийтэд хүргэсэн /2017 оны ТАХ/ мэдээлэл болон зарим сумдын 2016 онд самбарт байршуулж байсан мэдээллийг шалгахад ОНХС-ийн төлөвлөгөө, санхүүжилтийн мэдээллийг байршуулсан байна.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлнэ” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгахад аймгийн ТЕЗ-ын шилэн дансны нэгдсэн систем дэх цахим хуудсанд аймгийн ОНХС-ын төлөвлөгөө, санхүүжилтийн мэдээлэл, dornogovi.gov.mn цахим хуудсанд төлөвлөгөө, иргэдийн оролцооны тухай мэдээллийг мэдээлсэн байна.

Мөн сумдын ТТЗ-ийн шилэн дансны нэгдсэн систем дэхь цахим хуудсанд хуульд заасны дагуу ОНХС-ийн төлөвлөгөө, санхүүжилтийн мэдээллийг бүрэн мэдээлжээ.

3.4 ОНХС-ийн заавар холбогдох хууль, тогтоомжтой нийцэж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна. Энэхүү заавар нь Монгол Улсын Төсвийн тухай, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам” зэрэг хууль, эрх зүйн актуудтай нийцсэн байна.

3.5. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

ОНХС-ийн 2014 оны зарцуулалтад хийсэн аудитаар өгөгдсөн, хугацаандаа хэрэгжээгүй албан шаардлагыг дараах хүснэгтэд харуулав. /Хүснэгт №5/

2014 оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгөгдсөн хэрэгжээгүй албан шаардлагын жагсаалт /төгрөг/

/Хүснэгт №6/

№	Дугаар	Хариуцагч байгууллага, албан тушаалтан	Утга	Дүн /төгрөгөөр/	Барагдах огноо
1	07 23	ЗҮ сумын ЗДарга М.Баянмөнх	Агаарын шугам өргөтгөх ажлыг данс бүртгэлд тусгаагүй	47,050,899	2015/06/15
2	07 30	Хатанбулаг сумын ЗД М.Мөнхбаяр	Соёлын төвийн барилгын засварын чанаргүй хийгдсэн ажлыг дахин гүйцэтгүүлэх	30,000,000	2015/06/15
3	07 32	Алтанширээ сумын ЗД Н.Болдсайхан	Гудамжны гэрэлтүүлгийн ажлыг дуусгуулах	27,950,000	2015/06/15
Нийт дүн				105,000,899	

ЦДАШ-ыг данс бүртгэлд тусгах зөвшөөрөл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирээгүй, гүйцэтгэгч байгууллага ажлыг дуусгаагүй шалтгаанаар шүүхэд шилжүүлсэн зэргээс 2015 онд бичигдсэн албан шаардлага биелэгдээгүй байна.

2015 оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага бүрэн хэрэгжээгүй байна. /Хүснэгт №7-8/

2015 оны ОНХС-ийн зарцуулалтын аудитаар

тогтоосон актын хэрэгжилт /төгрөг/

/Хүснэгт №7/

№	Дугаар	Огноо	Утга	Хариуцах албан тушаалтан	Дүн /төгрөгөөр/	Барагдуулах огноо	Хэрэгжилт
1	07/19	2016.04.27	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг төлүүлэх тухай	ЗҮ Засаг дарга М.Баянмөнх	3,487,821	2016.06.25	Хэрэгжээгүй
Нийт дүн					3,487,821		

2015 оны ОНХС-ийн зарцуулалтын аудитаар өгөгдсөн

албан шаардлагын хэрэгжилт /төгрөг/

/Хүснэгт №8 /

№	Дугаар	Хариуцагч байгууллага	Утга	Албан шаардлагын дүн /төгрөгөөр/	Үүнээс хэрэгжсэн дүн	Барагдах огноо
1	07/17	Замын-Үүд сумын ЗДТГ	Хөрөнгө данс бүртгэлд тусгуулах тухай	77,788,155	-	2016.06.30
2	07/18	Аймгийн ЗДТГГазар	Хөрөнгө данс бүртгэлд тусгуулах тухай	354,980,000	-	2016.06.30
3	11/19	Сайншанд сумын ЗДТГ	Хөрөнгө данс бүртгэлд тусгуулах тухай	49,125,014	44,525,014	2016.06.30
4	07/20	Сайншанд сумын ЗДТГ	Хөрөнгө данс бүртгэлд тусгуулах тухай	758,000,000	758,000.000	2016.06.30
5	07/36	Аймгийн ЗДТГГазар	7 сумын Засаг даргад хариуцлага тооцуулах тухай	-		2016.06.30
Нийт дүн				1,239,893,169	802,525,014	

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн ЦДАШ-ыг данс бүртгэлд тусгуулах тухай албан бичгийг АЗДТГ-аас 2015 оны 12 дугаар сард Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн боловч, хариу ирүүлээгүй байна. Иймд хөрөнгийг бүртгэх тухай 432.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хэрэгжээгүй.

Мөн 2015 оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

Зөвлөмж 1: Тухайн онд ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг аймаг болон сумдын дараа жилийн төсөвт тусгаж батлуулах

*Хэрэгжилт:*Замын-Үүд сумаас бусад сумдад төсөвт ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг аймаг болон сумдын дараа жилийн төсөвт тусгаж батлуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Зөвлөмж 2:*Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төрийн өмчид бүртгэгдэх ЦДАШ-ын ажлуудыг данс бүртгэлд тусгуулах ажлыг зохион байгуулж, хариу ирүүлэх.

*Хэрэгжилт:*Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраа хөрөнгийг бүртгэлд тусгах зөвшөөрөл ирээгүйн улмаас ЦДАШ-ыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

*Зөвлөмж 3:*Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 9.2 дахь заалтыг үндэслэн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад гүйцэтгэлийн болон санхүүгийн хяналт шалгалт хийж, дотоод хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.

*Хэрэгжилт:*Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 онд Айраг сумын ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн байна.

2013-2015 оны ОНХС-ийн зарцуулалтад өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг заасан хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Аймаг, сумдын ОНХС-д өмнөх оны зарцуулаагүй үлдэгдэл 135.8 сая төгрөг шилжин ирж, ОНХНС болон хандиваар 5614.7 сая төгрөг төвлөрсөн ба үүнээс 5556.4 сая төгрөгийг зарцуулж, 2016 оны жилийн эцэст 194.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Аймгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт зөвхөн ОНХНС-аас олгох шилжүүлгийг төлөвлөсөн байна.
3. Сумдад олгох орлогын шилжүүлгийг хууль журмын дагуу тооцоогүйгээс сумын ОНХС-д 512.1 сая төгрөгийг дутуу хуваарилжээ.
4. ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан байна.
5. Сумдад иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 11 ТАХ, зураг төсөвгүй 18 ТАХ, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт ороогүй 5 арга хэмжээг тус тус төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
6. ТАХ-ний үе шатны ажилд захиалагчаас тавих хяналтыг сайжруулах. Мөн захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтан, мэргэжилтэнд хуульд заасан хариуцлагыг тооцож ажиллах шаардлагатай байна.
7. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн, чанаргүй болон ашиглалтын шаардлага хангаагүй ажлыг гүйцэтгэсэн гүйцэтгэгчид гэрээнд заасан арга хэмжээг авч ажиллаагүй байна.
8. Засаг даргын дэргэдэх хяналт, шалгалтын байгууллага, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
9. Сумдууд ОНХС-ийн хэрэгжилтийн явцын мэдээ тайланг тогтоосон хугацаанд аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн боловч, аймгийн Засаг дарга ажлын хэсэг томилоогүйгээс ОНХС-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгдээгүй байна.
10. Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар нийт 2,533.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 36.2 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тавьж, 986.9 сая төгрөгийн 13 албан шаардлагыг бичиж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас: (705) 2-25-33, факс: (705) 2-23-30
E-mail: dornogovi_mgl@yahoo.com

2017-05-01 № 1/908
танай 2017-04-28 ны № 1-6/401 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

“Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт” сэдэвт нийцлийн аудитын тайланг төслийн байдлаар хүлээн авч танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой дараах тайлбар мэдээллийг гаргаж хүргүүлж байгааг хүлээн авч танилцан төслөөр хүргүүлсэн тайланд тусгагдсан аудитын мэдээллийг хянаж үзнэ үү. Үүнд:

1. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн 1.2. дахь хэсэгт **ОНХС-ийн эх үүсвэрийг боломжит хэмжээгээр төсөвлөөгүй** гэсэн дүгнэлт өгсөн байна.

“Доншен газрын тос” ХХК-ийн орон нутагт нийгмийн хариуцлагын гэрээний дагуу өгч байгаа 30,0 сая төгрөг нь “Шинэ Дорноговь” хөгжлийн сангийн дансанд ордог байсан бөгөөд тус данс 2016 оны 5 дугаар сард хаагдсан тул ОНХС дансанд төвлөрүүлсэн.

Аймгийн ОНХС-д орсон “Доншен газрын тос” ХХК-ийн 30,0 сая төгрөг, “Зон Хэн Юу Тиан” ХХК-ийн 4,8 сая төгрөгийг эх үүсвэрийг АИХТ-р батлуулаагүй нь шинэ ТАХ-нд нэмж батлахад өртөг бага, цаг хугацааны хувьд оройтсон тул 2017 онд уг эх үүсвэртэй ижил хэмжээний эх үүсвэрүүдтэй нэгтгэн томоохон хэмжээний ТАХ-г хэрэгжүүлэхээр тооцон батлуулаагүй оны эцэст дансны үлдэгдлээр үлдээсэн болно.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн дансанд оны эцэст 149,7 сая төгрөг үлдсэн болно.

2. Сумдад олгох орлогын шилжүүлгийг хуулийн дагуу тооцоогүй, батлагдсан төсвийг бүрэн хуваарилаагүйгээс сумдын ОНХС-д 512.1 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна гэсэн дүгнэлт өгсөн байна.

Засгийн газраас 2016 оны 08 сард Төсвийн тодотгол хийхдээ 820,0 сая төгрөгөөр аймагт олгох орлогын шилжүүлгийг хасч баталсан. Иймд аймгийн Засаг даргын бүрэн эрхийнхээ дагуу гүйцэтгэл нь бүрэн гарсан ажлуудын санхүүжилтийг бүрэн олгох, гүйцэтгэл нь дутуу явагдаж буй ажлуудын санхүүжилтийг дараа онд шилжүүлэн батлах бодлого барьж ажилласан.

Үүний дагуу аймгийн ОНХС-аас хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн олгохоор тооцон төлөвлөхөд ОНХС-ийн хуваарилалтад 7.1 хувийн зөрүү гарсан болно.

Иймд нийцлийн аудитын тайланд хүргүүлж байгаа тайлбарыг хүлээн авна уу.



Т.ЭНХТҮВШИН

2 2206

САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ЗДТГ-ын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 1/908 тоот албан бичгээр ирүүлсэн “Санал хүргүүлэх тухай” албан тоотыг үндэслэн дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

1. Аймгийн Аудитын газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудит болон нийцлийн аудитаар “Доншен газрын тос” ХХК-аас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгож буй хандивын орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн дансанд төвлөрүүлж байх, орон нутгийн хөгжлийн сангийн орлого, зарлагыг ИТХ-аар батлуулан ажиллах талаар зөвлөмж өгч байсан. Иймд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгож буй хандивын орлогыг ОНХС-ийн дансны эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулж ажиллах нь Төсвийн тухай хууль болон холбогдох журам, зааварт заагдсан тул “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт” сэдэвт аудитын тайланд засвар оруулах шаардлагагүй гэж шийдвэрлэв.
2. Ирүүлсэн тайлбартай уялдуулан тайланд засвар оруулав.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т заасан хувь хэмжээг баримтлан батлах.
2. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын 6.1, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын 8.7-д заасан орлогын төрлөөс боломжит эх үүсвэрийг ОНХС-ийн төсвийн төсөлд тусгасан байдалд хяналт тавьж, хэлэлцэн батлах.
3. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр бүлгийн 9.1-д заасны дагуу хяналт тавьж ажиллах.

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т заасан хувь хэмжээгээр тооцон хуваарилах.
2. ОНХС-ийн төсвийн төсөлд Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын 6.1, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын 8.7-д заасан орлогын төрлөөс боломжит эх үүсвэрийг тусгаж, батлуулах.
3. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2, 10.3-т заасны дагуу ажлын хэсгийг томилж, тухайн ажлын хэсгийн чиг үүргийг хангуулж ажиллах.

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын 8.7-д заасан орлогын төрлөөс боломжит эх үүсвэрийг ОНХС-ийн төсвийн төсөлд тусгасан байдалд хяналт тавьж, хэлэлцэн батлах.
2. Сумын иргэдийн саналаар дэмжигдэж, хамгийн их санал авсан, батлагдсан зураг төсөвтэй, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын 7.4-т заасан чиг үүрэгт хамаарах ТАХ-г хэлэлцэн баталж байх.
3. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр бүлгийн 9.1-д заасны дагуу хяналт тавьж ажиллах.

Сумдын Засаг дарга нарт:

1. Тухайн орон нутгийн төсөвт сумын иргэдийн саналаар дэмжигдэж, хамгийн их санал авсан, батлагдсан зураг төсөвтэй, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын 7.4-т заасан чиг үүрэгт хамаарах ТАХ-г тусгаж, батлуулах.

Сайншанд сумын Засаг даргад:

1. Иргэн Ц.Төрмөнхтэй байгуулсан хогийн сав нэмэгдүүлэх 4.9 сая төгрөгийн ажлын гэрээг дүгнэх.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 01/08

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 04 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйл, Ерөнхий аудиторов 2014 оны 121 тоот тушаалын хавсралтын 11, “Нийцлийн аудитын түр журам”-ын 09 дүгээр зүйлийн 03 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу 2016 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт” сэдэвт нийцлийн аудитын тайлан болон акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, сумдын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

4. Акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

0824826

Дарга, тэргүүлэх аудиторов 2017 оны 04 дугаар сарын 04-ны өдрийн 4/08 тоот тушаалын I хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

Д/д	Байгууллагийн нэр	Хариуцагчийн		Төлбөрийн актын		Мөнгөн дүн /сая.төг/
		Албан тушаал	Овог, нэр	Дугаар	Товч утга	
1	Сайншанд сумын ЗДТГ	Засаг дарга	С.Одбаяр	01/30 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг төвлөрүүлэх тухай	0.1
2	Сайхандулаан сумын ЗДТГ	Засаг дарга	Б.Эрдэнэжаргал	02/31 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг төвлөрүүлэх тухай	1.5
3	Хөсгөл сумын ЗДТГ	Засаг дарга	Н.Энхбаяр	03/32 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг төвлөрүүлэх тухай	0.7
4	Аймгийн ЗДТГ	Засаг дарга	Т.Энхтүвшин	04/33 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Илүү олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх тухай	20.7
5	Аймгийн ЗДТГ	Засаг дарга	Т.Энхтүвшин	05/34 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Илүү олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх тухай	13.2
Нийт дүн						36.2

Дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны ... дугаар сарын
01...-ны өдрийн 4/08 тоот тушаалын II хавсралт

Албан шаардлагын жагсаалт

Д/д	Байгууллагийн нэр	Хариуцагчийн		Албан шаардлагын		Мөнгөн дүн /сая.төг/
		Албан тушаал	Овог, нэр	Дугаар	Товч утга	
1	Сайншанд сумын ЗДТГ	Засаг дарга	С.Одбаяр	01/34 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
2	Сайншанд сумын ЗДТГ	Засаг дарга	С.Одбаяр	02/35 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Бүртгэлд тусгасан хөрөнгийн өртгийг залруулах тухай	24.8
3	Сайншанд сумын ЗДТГ	Засаг дарга	С.Одбаяр	03/36 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Хөрөнгө бүртгэлд тусгах тухай	247.2
4	Замын-Үүд сумын ЗДТГ	Засаг дарга	Н.Алдарбаяр	04/37 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Хөрөнгө бүртгэлд тусгах тухай	563.7
5	Улаанбадрах сумын ЗДТГ	Засаг дарга	Ц.Эрхэмболд	05/38 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил бүрэн дуусгах, ашиглалтад оруулах тухай	
6	Хөвсгөл сумын ЗДТГ	Засаг дарга	Н.Энхбаяр	06/39 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
7	Сайхандулаан сумын ЗДТГ	Засаг дарга	Б.Эрдэнэжаргал	07/40 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Бүртгэлд тусгасан хөрөнгийн өртгийг залруулах тухай	68.4
8	Алтанширээ сумын ЗДТГ	Засаг дарга	Л.Цэцэгдарь	08/41 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Бүртгэлд тусгасан хөрөнгийн өртгийг залруулах тухай	82.8
9	Даланжаргалан ЗДТГ	Засаг дарга	С.Уранцэцэг	09/42 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
10	Айраг ЗДТГ	Засаг дарга	Л.Мөнхжаргал	10/43 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
11	Айраг ЗДТГ	Засаг дарга	Л.Мөнхжаргал	11/44 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
12	Иххэт сумын ЗДТГ	Засаг дарга	О.Энхтуул	12/45 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
13	Иххэт сумын ЗДТГ	Засаг дарга	О.Энхтуул	13/46 УАГ-НАГ/2017/01-НА-ДГА	Ажил дуусгуулах тухай	
Нийт						986.9